

МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль  
“ТАВАН ӨНГӨ ДӨРВӨН ХАРЬ ЕСӨН ИХ УЛС”  
ХЭМЭЭХИЙН УЧИР

Д.ЦОГТСАЙХАН

Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль

**Түлхүүр үг:** Ертөнц дахиныг нэгтгэсэн улс, Хөх Монгол, Улаан Хятад,  
Хар Түвэд, Шар Сартаул, Цагаан Солонгод

Монгол түүх бичгүүдийг эш болговол, “Таван өнгө, Дөрвөн харь Есөн Их Улс” хэмээхүй Чингис хааны үндэслэсэн гүрээ улсын тодотгол нэр болно. “Монголын нууц товчоон”-оос бусад түүхнээ ямагт хэрэглэх энэхүү нэрийг анх Чань Чунь (Чу Цзи, 1147-1227) хэмээх даогийн их аршийг урьж илгээсэн Чингис хааны захидал бичигт (1219 он)<sup>1</sup> дурддаг ч “Цагаан түүхэнд” тэмдэглэсэн Хубилай (1215-1294) хааны зарлигууд албан ёсоор мэдээлдэг болно. Монгол хэлээр, өөрөөр хэлэхүл хятад сурвалжаас ангидаар бидэнд ирсэн тэдгээр зарлигт: “Хубилай нэрт... дөрвөн их дайду төрийг байгуулж төгсгөн, Таван өнгө, дөрвөн харь Их Улсдаа ийн зарлиг болорун...”; “Таван өнгө, дөрвөн харь Их Улс дор арвадын ах, тавьтан, зуутан, мянгатан, түмтэн, түг түмний ноён ану улс, аймаг аймгаа тус бүр мэдтүгэй...”; “Думд бүхий хөтлөхүйн дээд Их Монгол, дорно Солонгос, Битэгүн хоёр, өмнө Хятад, Гэлияд хоёр, өрнө Балба, Сартул хоёр, умар Тэшиг, Түвэд хоёр – Таван өнгө, Дөрвөн харь Есөн Их Улс дор аюугу мэт тунхвай”<sup>2</sup> хэмээн зааж өгүүлсэн буй.

Харин, хятад сурвалжууд нангиад газар байгуулсан Хубилайн улсыг “Юань” хэмээн нэрийддэг нь Хубилай тэрбээр хятадыг “тойндоо (мэдэлдээ) оруулж”<sup>3</sup>, ерөнхий бүгдийг энхжүүлэн жаргуулэх” их төрийн хаан<sup>4</sup> болох бодлого боловсруулахдаа “уг язгуур”, “өнө удаан”, “энх түвшин”, эсхүл “анх тэнгэр”, “аугаа их”, “орчлон ертөнц” гэсэн утга бүхий хятад үгийг<sup>5</sup> сонгож,

<sup>1</sup> Чань Чунь бүмбын Өрнө зүгт зорчсон тэмдэглэл. Хятад хэлнээс монгол хэлнээ хорвүүлсэн. Н.Ариунгуяа, УБ.: Есон-Эрдэнэ, 1997, 70 дахь тал

<sup>2</sup> Арван буянт номын Цагаан түүх. Лю Жин Сувь хэвлэлд бээлгэв. Хох хот: 1981, 76 болон 86-87 дахь талууд (цаашид.-Цагаан түүх)

<sup>3</sup> Лувсанданзан, Эртний хаадын үндэслэсэн тор ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэм ўх оршивай. Оршил бичсэн Ш.Бира. Гар бичмэл эхээс гэрэл зураг бэлтгэсэн С.Торбат, УБ.: УХГ., 1990, 132-134 дүгээр хуудас (цаашид.-Алтан товч)

<sup>4</sup> Эртний монголын хаадын үндэсний Их Шар тууж оршивай.-Шира туджи. Монгольская летопись XVII в., Сводный текст, перевод, введение и примечания Н.П.Шастиной, М.-Лг.: 1957, 49-50 дахь тал (цаашид.-Шар тууж)

<sup>5</sup> Далай Ч.. Монголын түүх (1260-1388). Гутгаар дэвтэр. УБ.: 1992, 43 дахь тал; Огахи Мацуво. Хубилай хаан, УБ.: Соёмбо, 1991, 100 дахь тал; Нацагдорж III., Хубилай сэцэн, УБ.: Адмон, 1998, 25-26 дахь тал

улсаа Их Юань Улс хэмээн нэрийдэх зарлиг<sup>6</sup> (1271 он) буулгасан нь монгол гүрний нэр лүгээ адилшаан үзэхэд хүргэсэн байна. Монголчуудын улс төрийн үзэл баримтлалыг нь илтгэсэн эл баимвт, өдгөө ч Хубилай бол хятадын шинэ мандсан буюу монголчуудын байгуулсан хятад улсын<sup>7</sup>, эсхүл хятад, монголыг хамтад захирсан буюу хятадыг эрхшэсэн монгол гүрний хаан<sup>8</sup> гэх зэрэг судалгааны санал дэвшүүлэх үндэслэл болсоор байгааг нягглавал, тэрбээр “Тайзу (Хубилай хаанаас Чингис хаанд нэхэн өргөсөн хятад цол, - Д.Ц.) хааны тогтоосон хуулиар” ертөнцийг засах, хятад иргэнийг нэгмөсөн захирахын тул тийнхүү нанхиад газар байгуулах улсаа “Юань” хэмээн нэрийдэж, өөрөөр хэлэхүл хятад “ заншилаар”, хятад хүний сэтгэл зүйд нөлөөлөх санаа өвөрлөсөн нь илэрхий байдаг. Иймийн учир Монгол улс хийгээд Монгол гүрэн аль алийг эс төлөөлөх эл нэр хятадын түүх бичлэгт л баттай орж, монгол төрийн түүхнээс эзэнт гүрний сүр сүлдээр дулдуй баригч зарим хаадын цол, чимэг сэлтээс ер хэтрээгүйг зориуд тэмдэглэе.

“ТАВАН ӨНГӨ, ДӨРВӨН ХАРЬ ИХ УЛС” хэмээхүй чингэж нэрийдсэн үндэслэл энэ хир тодорхойгүй. Монгол түүх бичгүүдэд:

-“Сүмбэр уулын өмнө тал нь Улаан ли-гийн тал буй. Замбутив ертөнц хэмээмү. Түүнд есөн өнгийн улс бөлгөө. Есөн энгө бүлэг улс ину: Энэтхэг улс цагаан өнгөт буюу; Охин улс ногоон өнгөт буюу; Түвэдийн улс хар өнгөт буюу; Хятадын улс улаан өнгөт буюу; Гауль улс хөх өнгөт буюу; Васа улс хув өнгөт буюу; Нохой улс хүрэн өнгөт буюу; Эрээн улс ганц хөлт улс буюу; Монгол улс шар өнгөт буюу. Монгол улс дөрвөн өнгөт буюу; Цагаан монгол, Имагарийн өмнөд зүгт буй. Шар монгол Ачийн цэйдам дор аж. Улаан монгол хар хятад лугаа хамт суун бөлгөө. Хар монгол газраа аж... Монголд сод богд Чингис хаан таван их улсыг эрх дораа оруулав. Өмнө хятадын Ахудай хаан, Өрнө түвэдийн Шударга хаан, Умар сартуулын Султан хаан, Малиг хоёр, Дорно Солонгосын Буха цагаан хаан; дөрвөн зүгийн дөрвөн харьтан тэд бөлгөө...” (Лу.Алтан товч)<sup>9</sup>;

-“Түвэдийн Алтан сандалт хааны арван хүвүүний таван ах ану таван дүүдээ өмч эс өгсөнд, таван дүү инү салан одож, таван өнгө улс болов гэх.

<sup>6</sup> Дай Юан Улсын бичиг. Хятад хэлнээс Түдэн, Өлзийт, Саран, Соном орчуулэв. Улаан хад: ӨМАХХ., 1987, 178-179 дэх тал

<sup>7</sup> Санждорж М., Монголын төрийн түүхээс (ХIII-XIX зуун). Дундад зууны монгол төсөл. УБ.: “Цоморлиг төв. 1998, 66-68 болон 74 дэх талууд

<sup>8</sup> Охати Мацуво. Хубилай хаан. УБ.: “Соёмбо. 1991, 90 дэх тал. Нашагдорж Ш., Хубилай сүн. УБ.: Адмон. 1998, 25-26, 96-97 дахь талууд болон бусад

<sup>9</sup> Алтан товч, 129-130 дүгээр хуудас

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

Бөрту чинуа Хөх монгол омогтон болов; нэг инү Цагаан солонгос болов; нэг ану Шар сартуул болов; нэг ану Улаан хятад болов; нэг ану Хар тангуд болов гэх. Дөрвөн харь гэгч, энэ тавын нэгийг „дөрөвдөө харь болох” (Шар тууж)<sup>10</sup>; гэх зэрэг адил бусаар тайлбарласан нь илтэд цагийн аясыг дагаж, төөрөгдлийн мананг үүсгэсэн байна...Хэмээвч, нухацтай авч хэлэлцсэн нь гүн Гомбожав бөгөөд тэрбээр: “Таван өнгө, Дөрвөн харь Улс хэмээгдэх нь зарим судраа хөх Монгол, улаан Хятад, хар Түвэд, шар Сартаул, цагаан Солонгод; эд таван өнгө бөгөөд монголын ухаан тул инад бус дөрөв нь: дөрвөн харь буй хэмээжээ. Зарим таван өнгө урьд мэт дээр: ганц хөлт Зүд улс, Охин улс, Өвчүүндээ нүдэт улс, Нохой толгойт улс; эд дөрвөн харь буюу хэмээж. Эдгээр бараг судрын үг мөн боловч шинжилбэл, тэдгээр улс цөм Богдын соёл дор дагасан ноён атлаа тэдэнд тэр мэт өнгө хадах, харь болгох учрын барилдлага тодорхойгүй. Түүнээс харин Чингис богд олон өөр ёстныг эрхэндээ хураасан атлаа... Чан чун чау жи (Чань Чунь.-Д.Ц.) аршийг... урьж, ...төрийг барих, амьтныг тэтгэх ёсыг асууж сайшаан магтаад, “Төв тэнгэр” цол өргөж, багшийн ёсоор хүндэлснээс эхлэн хойш Өгэдэй эзэн, Сэцэн хаантан аливаа зарчим, журэм, хууль ёсыг цөм хятадын ёсоор зохиосныг бодвол, сүдруудад Энэтхэгийн шашны хаан, Хятадын төрийн хаан хэмээн номлосон лугаа утга төгөлдөр мэт байнам. Түүгээр үлиж сууваас есөн өрлөг нь есөн чин хэмээгдэх төрийн буй үгүй есөн зүйл үйлийг даасан эрхэм сайдын хийгээд, таван өнгө нь гүн, шан, жиу, жи, юй таван махабодын таван чанарт, таван зүйл багтсан эл гол улс иргэн ба дөрвөн харь нь зи ай хэмээгдэх Дундад улсын дөрвөн зүйт агч алба өргөн ивээл дор хүртэгч эл гадаад улс нийтийн нэр бөгөөд хятадын аху ёсны өгүүллийг дагаж монголчлон орчуулсан мэт байна”<sup>11</sup> хэмээжүүй.

Гомбожавын эл тайлбарлалаас “Таван өнгө, дөрвөн харь” хэмээх нь нанхиад соёлын хүрээнээ анхлан боловсруулсан ойлголт бөгөөд монголчууд хуулбарлаж бус, боловсруулж хэрэглэсэн болохыг эн тэргүүнээ анхаарах ёстой. Гэхдээ энд эл томъёоллыг хэрхэн ухан ойлгож, чухам юуны учир, ямар зорилгоор авч хэрэглэсэн тухайд дэл эрүүлж өгүүлсэнгүй.

Сүүлийн үеэс нэлээн анзааран судалж: монголчуудын газарзүйн хийгээд угсаатны мэдлэгийг илтгэсэн бэлгэдээп томъёолол<sup>12</sup>, нэгэн зүйл

<sup>10</sup> Шар тууж, 95 дахь тал

<sup>11</sup> Гангын ургал, 22-23 дахь тал

<sup>12</sup> Жуковская Н.Л.: (Категории и символика традиционной культуры монголов. М.: Наука, 1938. с.138, 154; Шастрина Н.П., Шира туджи. Могольская летопись XVII в., Сводный текст, перевод, введение и примечания Н.П.Шастриной. М.-Лг.: 1957. с.177-179; Дулам С., Монгол бэлгэдэл зүй. Дэд дэвтэр. Онгоний бэлгэдэл зүй. УБ.: МУИС.. Адмон, 2001

ертөнцийн загвар<sup>13</sup>, Азийн ард түмнүүдийн оюуны нэгдмэл байдлаас улбаалсан эзэнт гүрний нууц, битүү далд утга бүхий (эзотери) нэр<sup>14</sup>, эсхүл" ...хожмын хүмүүсийн санаагаараа буюу судалгааны үндсэн дээр гаргаж ирсэн зохиомол шинжтэй зүйл"<sup>15</sup> гэх зэргээр тайлбарлаж буй; эл бүгдийг Хубилай хааны зарлиг лугаа тулгаж нягталбал:

-“таван өнгө, дөрвөн харь” нь нүүдэлчдийн язгуур соёлын, эсхүл даогийн (хятадын) хийгээд буддын (энэтхэг, төвдийн) соёлын аль ч хүрээнээ ертөнц дахиныг нэгтгэсэн улс гэсэн нэг л утгыг илтгэх аж. Иймийн учир аль нэг соёл буюу нарийнаа хэлэхүл, шашин-гүн ухааны сургаалаар үндэслэх, эсхүл “эртний азийн философи”<sup>16</sup> юмуу, ерөөс эзэнгүйдэх (космополит) байр сууринаас тайлбарлах, аль аль нь өрөөсгөл байж болзошгүй байна...

-Бидний ажигласнаар, эл махабодын бэлгэдлээс тоон бэлгэдэл илүү утга учиртай байна. Ертөнцийг үзэхүй бөөгийн үзэл хийгээд аливаа шашин (соёл, суртахуун)-д тэгш хандах “Их засаг” хуулийн хамт<sup>17</sup>, монголчуудын язгуур соёл дахь “авах, гээхийн ёсон (зарчим)” тэргүүтэнг харгалзан үзэхүл. Таван өнгө улс нь бэлгэдэл утгаараа таван тусгаар улс (1:1:1:1:1) бус, харин ч таван махабод лугаа шүтэн барилдсан нэг улс<sup>18</sup> (1+1+1+1=5) бөгөөд эл улсын дөрвөн зүйт оршигч нь дөрвөн харь (букуу хөрш) болох тул Хубилай хаан тийнхүү ЕСӨН ИХ УЛС (5+4=9) дор тунхаж асан<sup>19</sup>; үүнд, тавьан өнгө

<sup>13</sup> Скрынникова Т.Д., Харизма и власть в эпоху Чингис-хана, М.: Восточная литература, РАН, 1997, с.87-88

<sup>14</sup> Урбанаева И.С.(Человек у Байгала и Мир Центральной Азии: философия истории. Автореферат докторской диссертации на соискание ученой степени доктора философских наук, УБ.: 1994, с.18-20

<sup>15</sup> Дам эшлэв, - Санждорж М., Монголын төрийн түүхээс (XIII- XIX зуун). Дундад зууны монгол төсөл, УБ.: “Цоморлийтөв”, 1998, 45 дахь тал

<sup>16</sup> Мөн тэнд, с.18

<sup>17</sup> Аливаа шашин бүгдийг нэгэн адил үзэж байваас зохих бөгөөд нэгнийг дээр, нэгнийг дор хэмсэн ялгаварлан үзэхийг хориглосугай, Сүхбаатар Г., Монголын түүхийн дээж бичиг. II дэвтэр, УБ.: СБХНХГ., 1992, 20 дахь тал

<sup>18</sup> Дэлэгэрүүлж үзнэ үү: Лукьянов А.Е. Становление философии на Востоке (Древний Китай и Индия), М.:ИНСАН, 1992, с.34-56; Истоки Дао, М.:ИНСАН РМФК, 1992, с.41-45

<sup>19</sup> МНТ-ны 254-255§ зүйлд тэмдэглэсэн Чингис хааны гэрээс сургаалын үзэл санаа үүний нутлагаа болох юм: ...Чингис хаан огүүлрүүн: Алтан аргамжаа Сартуул иргэнд яахин таслуулах болгөө?” хэмсэн Ухуна тэргүүтэн зуун элчинийнхээ ошил, хясал хясан Сартуул иргэнд морилёо хэмээн морилохуйд, тэнд Есүй хатан Чингис хаанд дуртган очруун: “Хаан, ...Тулгуур мэт бие чинь тулбис одвоос, түял мэт улсаа хэнд гэмүү?... Ховууд дүү нар, олон харцас мануус үл ухаарч сууна ...Зарлиг мэдгүгэй” хэмсэн очвөөс Чингис хаан зарлиг болорун: “Хатан хүмүүн бөгөөтол Есүйн үг зовоөс юв! ... Ховуудийн минь ах Жечи буй за, юу хэмээму чи хэл” хэмээв. Жочиж дуугарахын урьд Цагадай огүүлрүүн: Жочиж хэл хэмээхдээ Жочиж юүгий түшиж өгүүлжүй? Энэ мэргэдийн цулхалзуурт бил хэрхэн мэдүүлнэ?” хэмээхүйд Жечи босоод Цагаадайн заамнаас шүүрч огүүлрүүн: “Хан эцэгт бусдын эс хэлэгдлээ... Абалдаж барилдаж чамд ялагдваас унаасан газраас бүү боссугтай! Хан эцгийн зарлиг мэдтүгэй!” хэмээв. Жочи, Цагадай хоёр заамнаасаа барилцаж байн бүхүйд ...Хохечос огүүлрүүн: “Таныг төрөхийн урьд: Одтой тэнгэр орчиж бөлгээ. Олон улс тулалдан болгоо, Тийм цагт, хүслээр эс явав зэ... Хан эцг тань хамаг улсыг байгуулахад... эх тань хамтаар зовохдоо... эрийн эгэмд, агтын харгамд хүргэж, эдүгээ та нарынхаа сайнны үзье хэмээн санаж байгаа биш үү...” хэмээв. Чингис хаан огүүлрүүн: “Жочиж яхин тийн хөлнэ чи ? Ховуудийн минь ах Жочи биш гэж

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

дөрвөн харийн барилдлага нь эв зе хийгээд эрх тэгшийг бэлгэдэж<sup>20</sup>, улс төрийн агуулгаараа төрийн алтан жолоо (дотоод) хийгээд аргамжийн (гадаад) бодлогоо<sup>21</sup> илтгэж, өрөнхийлөн өгүүлбээс "улсыг шударгатгаж"<sup>22</sup>, "хөл хөсрөө, гар газраа тавиулж жаргуулах"<sup>23</sup> монгол төрийн уламжлалт номнолыг тийнхүү гүрэн улсын шинэ нэрээр шинэчлэн томъёолсон гэж үзмээр байна;

-Хожмоо, таван өнгө улсын нэг нь дөрөвдөө харь (1:4) гэх зэргээр тайлбарласан нь хэдүй зохиомол шинжтэй ч нэгэнт задарч мөхсөн гүрэн улсын ор суурин дээр буй болсон шинэ улсуудын нийгэм-улс төрийн харилцааг илтгэн буй нь: Хөх Монгол бол Монголын эзэнт гүрний зүй ёсны залгамжлагч бөгөөд бусад лугаа эн зэрэгцэх. тусгаар улс болохыг улс төрийн шинэ орчноо нутлах хэмээсэн хэрэг. Иймийн учир, монголын буюу Чингисийн алтан ургийн хаадын улсыг монгол түүх бичгүүд "таван өнгө, дөрвөн харь" хэмээн нэгэн дугаар тодотгож нэрлэдэг нь зүйн хэрэг бөгөөд харин гагц Хөх Монголоо захирсныг нь тийнхүү "бага" хэмээн зааглаж хэлэлцдэг байна. Үүгээр үзэхүл, ХӨХ МОНГОЛ нь монгол их хаадын гол улс (1206?-1368) бөгөөд "монголын тэдүй" хаадын бүрэн улс<sup>24</sup> (1371-1634); монголчууд Манж Чин Улсад (1616-1911) бүрнээ автах хүртэл, өөрөөр хэлэхүл аргын 1758 он хүртэл оршин тогтножухуй.

Чингэж үзэх ахул, наад зах нь Монгол Улсын нэрийн тодорхойгүй байдлыг цаг хугацааны талаас тодруулан хэлэлцэж болох байна. Хоёрт, монголчуудын төр, улсаа нэрлэсэн нэрийн цаана тэдний төрийг үзэхүй үзэл, улс төрийн номнол нь ямагт томъёологдож байдаг байна; үүгээр уламжлаад гуравт, монголчуудын төрийг үзэхүй үзэл (философи), улс төрийн номнолыг тухайлан шинжлэх явдал монголын нийгэм-улс төр, философи сэтгэлгээний

үү? Дараа тэгж бүү хэлэгтүн! хэмээн зарлиг болов. Энэ үгэнд Цагадай мушилзаж өгүүлрүүн: "Хөвүүдийн ах Жөчи бид хоёр буй за. Хан эшгээ хамсан хүчээ хүчээ огье. Өгэдэйг хэмээлдье. Өгэдэй хан эшгийн дэргэд байж бараа их малгайн байдал ёсыг таниваас болиу зэ" хэмээв. Жөчи өгүүлрүүн: "Цагадай бид хоёр хамсан хүчээ отье. Өгэдэйг эмээлдье" гэв. Чингис хаан зарлиг болруун: "Хамсах юу буй? Этугэн эх агуу буй. Ус мөрөн олон буй. Салгуу шиг нутгаа уужимстаж харь даргалан салгая" хэмээгээд "Жочи. Цагадай хоёр үгэндээ хүрэгтүн... Хасарын ураг нэгнээрээ мэдүүл! Алчидайн ураг нэгнээрээ мэдүүл! Отчигини ураг нэгнээрээ мэдүүл! Бэлгүдэйн ураг нэгнээрээ мэдүүл! Тэр ёсоор миний ургийг нэгнээр мэдүүлж, миний зарлигийг үл борчлон эс задалваас үл эндэн, үл алдана та нар. Өгэдэйн урагт өлонд хучивч үхэр үл идэх, өөхөнд хучивч нохой үл идэхээр төрвөөс миний ургийн нэгэнд сайг үл торне гэж үү?" хэмээн зарлиг болов".

<sup>20</sup> Дулам С., Монгол бэлгэдэл зүй. Тэргүүн дэвтэр. Тооны бэлгэдэл зүй, УБ.: МУИС., Адмон, 1999, 128 ба 97 дахь тал

<sup>21</sup> Жүгдэр Ч.. Монголд феодализм тогтох үсийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ (эртнээс ХІҮ зуун хүртэл). УБ.: ФСЭХ. ШУАХ., 1987, 106 ба 137 дахь тал

<sup>22</sup> МНТ., 202§

<sup>23</sup> МНТ., 279§; Цагаан түүх, 75 дахь тал

<sup>24</sup> Алтан товч, 106 дугаар хуудас, дээд болон бусад

түүх судлал, ерөөс монгол судлалын өмнө дээшин гарч буй тулгам нэгэн асуудал мөн хэмээн үзмээр байна.

### THE MEANING OF A PHRASE "FIVE COLOR AND FOUR STRANGER-GREAT NINE STATES"

#### (Summary)

According to the historical texts, the phrase "Five color and four stranger-great nine states" is the definition of a great empire founded by Chinggis Khaan. This attributive name, which is always used in all historical books except "Secret History of Mongolia", was first officially reported in the decrees of Khubilai Khaan (1215-1294) which was recorded in "White History". In these decrees, which came down to us, Mongolians, from other sources than Chinese, they say that "When the named Khubilai founded four-great states, Five color and Four stranger Great States he ordered, "In the Five color and Four stranger Great State each chief of unit of tens, fifties, hundreds, thousands, twelve thousands, myriad should be in charge of their people and aimags ..." reported in White History.

But the reason why Mongolians used this name for their empire is still unclear. Most of the explanations given in Mongolian historical texts are legends and were made in different ways that in the course of time was led to misconception.

Quite seriously discussed version was made by Gombojav ("Stream of steel"). Recently, it was paid attention that according to (N.L.Jukovskaya, S.Dulam) it is symbolized terminology showing geographical and ethnic knowledge of Mongolians, (T.D.Scrinnikov)-one kind of world pattern, (I.S.Uranova)secret and hidden meaning of empire (esoteric) derived from unified nature of mind of Asian people, or it is explained as an "artificial terminology that created on the basis of thought or research of people of later time".

In our view of point, within any of the following cultures-whether it is fundamental culture of nomads, or dao (China), or Buddhist (Indian and Tibetan) culture, "five colors and four strangers" means that it is a state that consists of the whole world. For this reason, explanation of this name on the basis of the culture, to be exact, one religious and philosophical doctrine, or from the position of "ancient Asian philosophy" or impersonal attitude, might be biased to one side. Because, numerical symbol has more sense in this name than that of the five element. Taking into account world view of shamanism, provision of law "Ikh Zasag" that

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

equally treats any religion (culture, ethics), and one of the principle of Mongolians original culture—"principle of taking the usefulness and loosing the useless", in its symbolized sense the Five color state means not five separate states, but instead it is one state with correlated five elements and in the four direction of it there are four stranger states (or neighbors) that all together Khubilai Khaan declared to the world the Nine great State ( $5+4=9$ ): here correlation of five color and four stranger symbolizes equality, in the political sense it expresses golden rein of state (inner) policy and tethering (external) policy, in a general way "to found a state with peace well-being" (SHM), is the traditional doctrine of Mongolian state that were newly formulated.

Later, although the explanation like one of the five color state is stranger to the other four (1:4) is an artificial one, it expresses social and political relation of newly founded states on the base of collapsed empire: here there was an attempt to prove in the new political environment that Blue Mongol was a rightful successor of Mongolian Empire and that it is equal with others, and is an independent country.